## АРХАНГАЙ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

### Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан

2026 оны 06 дугаар сарын 04 Эрдэнэбулган сум

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 05 | 5.3 | Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2026.04.08-ны өдрийн 05 дугаар албан даалгавар | Монгол улсын 2026 оны нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлт, төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлагатай уялдуулан эрэмбэлж санхүүжүүлэх зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд З.Мэндсайхан, бүх шатны төсөв захирагч нарт | -Төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй арга хэмжээ, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн хэрэгцээг бодит гүйцэтгэлтэй уялдуулан хянаж, үр ашиггүй болон шаардлагагүй зардлыг бууруулах талаар зөвлөмж хүргүүлсэн.<br>-Төсвийн байгууллагуудын өр авлага үүсгэхгүй байх, гэрээт үүргээ төсөв, санхүүгийн эх үүсвэртэйгээ уялдуулан хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажилласан.<br>-Дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд төсвийн сахилга бат, хяналтыг сайжруулж, төрийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна. | 100% | | |
| | 5.8 | | Шинээр чиг үүрэг болон албан тушаал бий болохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэрт гарсан албан тушаалын мул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, аймаг нийслэлийн Засаг дарга нар, бүх шатны төсвийн шууд захирагч нарт | -Тус газрын дарга нь 2025 оны 12 дугаар сарын 15-нд өндөр насны тэтгэвэрт гарч сул орон тоог нөхөх захиалгыг Төрийн албаны зөвлөлийн аймгийн салбар зөвлөлд хуулийн дагуу хүргүүлсэн. Салбар зөвлөлөөс сонгон шалгаруулалтыг зарлаж хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг аймгийн засаг даргын захирамжаар 2026.04.01-ний өдрөөс томилоод байна. Тус албан тушаал нь төрийн албаны удирдах албан тушаалд хамаарах бөгөөд байгууллагын үндсэн чиг үүргийг хэвийн хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай орон тоо байсан тул холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн албаны сул орон тооны сонгон шалгаруулалтыг зарлаж, сонгон шалгаруулалтын | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | үр дүнд томилогдсон албан хаагчийг нөхөн томилсон.<br>-Ингэхдээ байгууллагын бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулаагүй, шинээр албан тушаал бий болгоогүй бөгөөд батлагдсан орон тооны хүрээнд хүний нөөцийн зохицуулалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | | | |
| **Засгийн газрын 2025 оны албан даалгавар /2026 онд үргэлжлэн хэрэгжүүлж байгаа/** | | | | | | | |
| 1 | 1 | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай 2025-06-18 Дугаар 2025_01 | 1.1.Шинжлэх ухааны судалгаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж, ард иргэдээ сонсон, итгэл, хүлээлт, шаардлагад нь нийцэж ажиллах; | Иргэд байгууллагаас 2026 оны эхний хагас жилд ирсэн нийт 11 өргөдөл хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэн хуулийн хугацаанд хариу тайлбар өгч ажилласан байна. Үүнд :<br>-Хяналт шалгалт хийлгэх хүсэлт 3<br>- Актаас чөлөөлүүлэх тухай 1<br>-Акт хуваан барагдуулах тухай 8 | 100% | | |
| | 2 | | 1.2.Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах; | Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдал, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гаргуулан ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг нэмэгдүүлэх үүднээс 2026 оны 04 дүгээр сарын 13-нд Ёс зүйн дэд хорооноос "Төрийн албан хаагчийн ёс зүй сэдэвт" дотоод сургалтыг зохион байгуулсан. Мөн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороо ажиллаж байна. | 100% | | |
| | 3 | | 1.3. Яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх; | Байгууллагын 2026 оны санхүүгийн тайлангийн жилийн гүйцэтгэлээр төсвийн хэмнэлт, хэтрэлтийг Шилэн дансны нэгдсэн сайтад байршуулсан.Төсөвт байгууллагуудын орон тоо, хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхээр 13 байгууллагад дотоод аудит, 13 давхардсан тоогоор байгууллагад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчилд зөвлөмж чиглэл өгч, зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллаж байна. | 100% | | |
| | 4 | | 1.5. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан, | Төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах тал дээр онцгой | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах бодитой ажлыг зохион байгуулан, тодорхой ахиц гаргаж, үр дүнг тайлагнах; | анхаарч төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийг өдөр тутамдаа хэрэглэж, ERP системээр ирсэн бичиг 139, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар 11, ирсэн өргөдөл гомдол 11-ийг хүлээн авч шуурхай шийдвэрлэсэн. | | | |
| | 5 | | 1.6.Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Хамаарахгүй. | | | |
| | 6 | | 1.7.Салбарын хэмжээнд нэн тулгамдсан, шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай асуудлыг Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд тусгуулан, шуурхай шийдвэрлэх; | "Алсын хараа 2050", "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө болон, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэн тулгамдсан, шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай асуудлыг тусган хэрэгжилтийг тайлагнан ажилладаг. | 100% | | |
| | 7 | | 1.8.Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаанд оролцох журмыг чанд мөрдөж, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдтэй нягт уялдаатай ажиллах, хүндэтгэлтэй хандах. | Хамааралгүй. | | | |
| | 8 | | 2.1. Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж, зөрчсөн үйлдэл гаргахгүй байх; | Хамаарахгүй | | | |
| | 9 | | 2.2. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг | Аймгийн тагнуулын газраас "Төрийн нууц" сэдвээр 2026 оны 04 сарын 14-ны өдөр сургалт авч Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамаарахгүй мэдээллийн жагсаалтыг гаргаж баталгаажуулан ажиллаж | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зохих журмын дагуу ил болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | байгаа бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нээлттэй байдлыг хангаж, байгууллагын цахим хуудас, веб сайт болон shilendans.gov.mn болон shilen.gov.mn хаягт байршуулан ажилладаг. | | | |
| | 10 | | 2.3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох; | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байгууллагын мэдээ, мэдээллийг ил тод байршуулах ажилтнаар дотоод аудитор Н.Нямсүрэнг томилж, тайлан мэдээг хуулийн хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.<br>Газрын www.cd.ar.gov.mn сайт, shilendans.gov.mn shilen.gov.mn болон Архангай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар" олон нийтийн сүлжээгээр дамжуулан байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг вэб сайтад 29 мэдээлэл, Facebook цахим хуудсанд 58 мэдээ нийт 87 мэдээлэл байршуулсан. | 100% | | |
| | 11 | | 2.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх; | Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг төрийн ажил үүргийг гүйцэтгэхдээ мөрдлөг болгон хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чандлан биелүүлэн ажиллаж байна. Авлига албан тушаалын , эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх талаар алба хаагчдад тогтмол сургалт явуулан ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулан ажилладаг. Байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог газрын даргын тушаалаар шинэлэн байгуулсан. Ёс зүйн дэд хорооноос 2026 оны 04 дүгээр сарын 13-нд "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт дотоод сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан бөгөөд 2026 оны хагас жилийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй. | 100% | | |
| | 12 | | 2.5. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр | Төрийн жинхэнэ албаны удирдах албаг тушаал буюу газрын даргын албан тушаалын сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу нөхөх арга хэмжээг авах захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дарамт, шахалт үзүүлэхгүй байх; | хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. Энэ дагуу салбар зөвлөлөөс сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 2026.03.02-ны өдөр зохион байгуулж хамгийн өндөр оноо авсан Д.Нэргүйбаатарыг аймгийн Засаг даргын 2026.04.01-ний 08 дугаар захирамжаар томилоод байна. | | | |
| | 13 | | 2.6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглахыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах. | Байгууллагын ажлын чиг үүргийн дагуу 13 байгууллагад дотоод аудит, давхардсан тоогоор 13 байгууллагад хяналт шалгалт хийж, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжилтийг хянан шалгаж 16 актаар 11.6 сая төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоон биелэлтийг хангуулан ажиллаж байна. | 100% | | |
| | 14 | | 3.2. Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж, үр дүнг тухай бүр тайлагнах, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох; | Хамааралгүй. | | | |
| | 15 | | 3.3.Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн, танилцуулсан, эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлыг бүрэн хариуцаж, гарсан шийдвэр, үр дүнгийн талаар олон нийтэд үнэн зөв, бодитой мэдээлэл өгч байх. | Хамааралгүй. | | | |
| 2 | 16 | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар | 1.1. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн үйлчилгээг хүргэх, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах үр дүнтэй ажлыг зохион байгуулан, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, | - Байгууллагын ERP, docX систем, тоон гарын үсгийг ашигласнаар нийт ирсэн албан бичиг 139, явсан албан бичиг 140-г цахимаар хүлээн авч, илгээж, холбогдох албан хаагчдад мөн адил цахимаар шилжүүлэн шийдвэрлэж, төсөв санхүү, цаг хугацаа хэмнэж байна.<br>- Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах шинээр хэрэгжиж эхэлсэн болон шинэчлэн найруулсан хууль тогтоомжтой, тогтоол | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2025-07-08 Дугаар 2025_03 | цахим шилжилтийг эрчимжүүлэх | шийдвэртэй холбоотой 21 мэдээ, шилэн дансны хөтлөлттэй холбоотой 6 мэдээл, хяналт шалгалттай холбоотой 4 мэдээ, төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой 4 мэдээ, авлигаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой 3 мэдээ, цаг үеийн шинжтэй мэдээ мэдээлэл 49 түгээн иргэд олон нийтэл мэдээлсэн байна.<br>Улсын байцаагч, дотоод аудиторууд ажлын баримт, холбогдох баримт, материалыг нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүйгээр нэгдсэн системээс мэдээллээ боловсруулж аудит хяналт шалгалтад хамруулж байна. | | | |
| | 17 | | 1.2. харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд сахилга, хариуцлагыг чангатгаж, төсвийн үр ашиггүй зардлыг танан, хэмнэлтийн горимыг чанд мөрдөх, бүтэц, чиг үүргийн давхардлыг арилган, орон тоог үе шаттай цөөлөх | - Сахилга хариуцлагыг нэмэгдүүлж, хэмнэлтийн горимыг мөрдөн өмнөх оны мөн үеэс бүтэц, чиг үүргийн давхардалгүй ажиллаж байна. | 100% | | |
| | 18 | | 1.3. Зарим чиг үүрэг, ажил, үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх талаар бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Байгууллагын албан конторын цэвэрлэгээ үйлчилгээг иргэнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. | 100% | | |
| | 19 | | 1.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх | Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдал, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гаргуулан ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг нэмэгдүүлэх үүднээс 2026 оны 04 дүгээр сарын 13-нд Ёс зүйн дэд хорооноос "Төрийн албан хаагчийн ёс зүй сэдэвт" дотоод сургалтыг зохион байгуулсан. Мөн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороо ажиллаж байна. | 100% | | |
| | 20 | | 1.5. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх | Төрийн жинхэнэ албаны удирдах албаг тушаал буюу газрын даргын албан тушаалын сул орон тоог | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх | Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу нөхөх арга хэмжээг авах захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. Энэ дагуу салбар зөвлөлөөс сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 2026.03.02-ны өдөр зохион байгуулж хамгийн өндөр оноо авсан Д.Нэргүйбаатарыг аймгийн Засаг даргын 2026.04.01-ний 08 дугаар захирамжаар томилоод байна. | | | |
| | 21 | | 1.6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах | Гадаад томилолтоор ажиллаагүй ба худалдан авалт хийгээгүй, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулаагүй. Дотоод томилолтын зардалд 2026 оны 05 дугаар сард 9.4 сая төгрөг зарцуулсан байна. | 100% | | |
| | 22 | | 2.1. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу албаны нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох | Аймгийн тагнуулын газраас “Төрийн нууц” сэдвээр 2026 оны 04 сарын 14-ны өдөр сургалт авч Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамаарахгүй мэдээллийн жагсаалтыг гаргаж баталгаажуулан ажиллаж байгаа бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нээлттэй байдлыг хангаж, байгууллагын цахим хуудас, веб сайт болон shilendans.gov.mn болон shilen.gov.mn хаягт байршуулан ажилладаг. | | | |
| | 23 | | 2.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцож ажиллах | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байгууллагын мэдээ, мэдээллийг ил тод байршуулах ажилтнаар дотоод аудитор Н.Нямсүрэнг томилж, тайлан мэдээг хуулийн хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.<br>Газрын www.cd.ar.gov.mn сайт, shilendans.gov.mn shilen.gov.mn болон Архангай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар” олон нийтийн сүлжээгээр дамжуулан байгууллагын үйл | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллагааны мэдээллийг вэб сайтад 29 мэдээлэл, Facebook цахим хуудсанд 58 мэдээ нийт 87 мэдээлэл байршуулсан. | | | |
| | 24 | | 2.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, бүх шатанд Ёс зүйн дэд хороодыг байгуулж үйл ажиллагааг нь идэвхжүүлэх | Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг төрийн ажил үүргийг гүйцэтгэхдээ мөрдлөг болгон хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чандлан биелүүлэн ажиллаж байна. Авлига албан тушаалын , эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх талаар алба хаагчдад тогтмол сургалт явуулан ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулан ажилладаг. Байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог газрын даргын тушаалаар шинэлэн байгуулсан. Ёс зүйн дэд хорооноос 2026 оны 04 дүгээр сарын 13-нд “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт дотоод сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан бөгөөд 2026 оны хагас жилийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй. | | | |
| | 25 | | 3.1. Улс, аймаг, сумын баяр наадам, тэмдэглэлт ой, бүх нийтийн амралтын улирал эхэлж байгаатай холбогдуулан ой, хээрийн түймэр, хүн, малын гоц халдварт өвчин, зам тээврийн осол аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, бүх төрлийн гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг мэргэжлийн байгууллагын удирдлага, зохицуулалт, иргэдийн идэвхтэй оролцоо, дэмжлэг, туслалцаатайгаар хэрэгжүүлэх | Хамааралгүй | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 26 | | 3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, намрын ургац хураалтын бэлтгэлийг хангах, бусад аймаг, сумдаас ирэх отор нүүдлийг Засгийн газраас тогтоосон маршрутын дагуу мэргэжлийн байгууллагын хорио цээр, хяналт шалгалтын дор хэрэгжүүлэх, отроор өвөлжүүлэх, хаваржуулах ажлыг гэрээний үндсэн дээр зохион байгуулахад анхаарч ажиллах | Тус газраас 2025 онд 4 боодол өвсний мөнгө болох 272.0 мянган төгрөгийг Архангай аймгийн Мал хамгаалах сангийн дансанд шилжүүлсэн.<br><br>Аймгаас 2026 онд хуваарилах өвс тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлэхээр заасан хуваарийн дагуу өвс бэлтгэн өгнө. | 100% | | |
| | 27 | | 3.3. аймгийн төв, хүн ам төвлөрсөн томоохон сум, суурин газрын иргэдийн орон сууц төрийн болон хувийн аж ахуйн нэгж байгууллагуудыг цахилгаан, эрчим хүч,% дулаан усаар найдвартай хангах, иргэдийг ая, тухтай өвөлжүүлэх, 2025-2026 оны өвөлжилтийн үеэр гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх | Хамааралгүй | | | |
| | 28 | | 3.4. Өсвөр насны хүүхдүүдийн дунд гарч байгаа улаан бурхан өвчний дэгдэлтийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд бууруулах, хяналтад авах өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулах | Байгууллагын нийт албан хаагчдын хүүхдүүдийн улаан бурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын судалгаа гаргаж алба бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн. | 100% | | |
| | 29 | | 3.5. Хичээлийн шинэ жилийн бэлтгэл, сургууль, цэцэрлэгийн | Хамааралгүй | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бэлэн байдлыг хангах, засварыг цаг тухайд нь хийж дуусгах, багшлах боловсон хүчний хангалтыг хэвийн болгох | | | | |
| | 30 | | 4.1. Ажлын байр шинээр бий болгоход шаардлагатай гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжиж, хүнд суртал, шат дамжлагыг халах, хөрөнгө оруулагчдад саад, дарамт, учруулж байгаа этгээдүүдэд хууль, журмын дагуу хариуцлага тооцож ажиллах | Хамааралгүй | | | |
| | 31 | | 4.2. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхдээ бус нутгийн эдийн засгийн хөгжлийн онцлог, нөөц боломж, давуу талыг харгалзан үзэх | Хамааралгүй | | | |
| | 32 | | 4.3. Түүх, соёлын дурсгалт газруудыг хамгаалах, аялал жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэх замаар орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | Хамааралгүй | | | |
| | 33 | | 4.4. Ажилтны мэдлэг, боловсролын түвшин мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд байнга анхаарч, давтан сургах, мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмшүүлэх | Ажилтны мэдлэг, боловсролын түвшин мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх үүднээс оны эхэнд сургалт хөгжлийн төлөвлөгөө боловсруулан нийт албан хаагчдыг хамруулж, одоогийн байдлаар нийт 23 сургалтад давхардсан тоогоор 66 албан хаагч хамрагдсан байна. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | | | | |
| | 34 | | 4.5. Хөдөлмөр эрхлээгүй иргэд, албан бус хөдөлмөр эрхлэлтийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сүлжээнд хамруулах арга хэмжээ авч, хөдөлмөрийн статистикийн тогтолцоог бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн чанарыг сайжруулж, ажиллах хүчний болон ажлын байрны судалгааг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах | Хамааралгүй | | | |
| | 35 | | 5. Энэ албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг сар бүр Засгийн газрын Хэрэг газарт ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, биелэлтэд нь хяналт тавьж явц үр дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод тус тус үүрэг болгосугай. | Хамааралгүй | | | |
| 3 | 36 | ЗАСГИЙН ГАЗРААС ШУУРХАЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ | 1.2. төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн | Тус байгууллага нь 2026 онд нийт батлагдсан орон тоо 12. Үүнээс гүйцэтгэлээр 8 орон тоотой ажиллаж байна. Өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан байхгүй. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2025-07-25 Дугаар 2025_04 | ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад; | | | | |
| | 37 | | 1.3.Иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад; | Байгууллагын дотоод журам, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг нарийвчлан тусгасны дагуу байгууллагын өдөр тутмын соёл болгон хэрэгжүүлэн мөрдөж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах үүднээс дотоод сургалтыг 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан. | 100% | | |
| | 38 | | 1.4. төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад; | Байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 11 дүгээр сарын 05-ны А/15 тушаалаар шинэчлэн байгуулж, үйл ажиллагаагаа хагас бүтэн жилээр тайлагнаж хэвшсэн. | 100% | | |
| | 39 | | 1.7.Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион | Төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргаагүй. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт; | | | | |
| | 40 | | 1.8.. ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх уулзалт, арга хэмжээг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт | Хамааралгүй | | | |
| *Хэсгийн дундаж хувь:100%* | | | | | | | |
| *Үнэлгээний дундаж хувь: 100%* | | | | | | | |